

I-III/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 10



### Барилгын өртөг өмнөх улирлаас 0.2 хувиар өссөн байна.


Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 133.3 болж, барилгын өртөг өмнөх улирлаас 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өслөө.

Харин орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 151.9 болж, барилгын өртөг нь өмнөх улирлаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өссөн байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 129.6 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 5.7 хувь, өмнөх улирлаас 0.1 хувиар өссөн байна. Орон сууцны бус барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөхөд сургуулийн барилгын өртөг 11.4 хувь, конторын барилгын өртөг 6.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 118.3 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өсөж өмнөх улирлаас өөрчлөлтгүй байна. Инженерийн барилга, байгууламжийн өртөг өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өсөхөд эрчим хүчний байгууламжийн өртөг 4.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1. Барилгын өртгийн индекс (2015=100), улирлаар, хувь



Хүснэгт 1. Барилгын өртгийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
	2015=100		
Ерөнхий индекс	<b>133.3</b>	<b>107.4</b>	<b>100.2</b>
Орон сууцны барилга	151.9	115.2	100.4
Орон сууцны бус барилга	129.6	105.7	100.1
Инженерийн барилга, байгууламж	118.3	100.8	100.0

### Ойлголт, тодорхойлолт:

Барилгын өртгийн индекс: Барилга, байгууламжийг барьж байгуулахад зарцуулж буй барилгын материал, машин, механизм, цалингийн үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Барилгын төрөл: Барилгын төрлийг орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн барилга, байгууламж гэж хуваана.

### Тооцох аргачлал:

Барилгын материал, цалин, машин, механизмын жинг тооцон, сонгогдсон барилгын материалын үнэ, машин, механизмын тариф, цалинг цуглуулж, тус бүрийн индексийг тооцно. Индексийг тооцохдоо Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглана.

$$I_1 = \frac{\sum P_1 Q_0}{\sum P_0 Q_0}$$

P0 - суурь үеийн үнэ,

P1 - тайлант үеийн үнэ,

Q0 - суурь үеийн тоо, хэмжээ

Эх үүсвэр: ҮСХ, Барилгын өртгийн мэдээ

Ангилал, код: ЭЗҮАСА, БҮНА

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 18



*Эдийн засгийн статистикийн газрын*

*дарга Э.Эрдэнэсан*

*Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын*

*статистикч Т.Жигжидсүрэн*

*Утас : (976-51)-261561*